

## Монгол бөөгийн онгодын хүч

Luvsanjav Chuluunbaatar

Монголын бөөгийн шашин нь монголчуудын дотор олон мянган жилээр үргэлжлэн шүтэгдэж ирсэн учир бөө мөргөлийг судлах явдал монголчуудын хэв заншил, үзэл санааны түүх, оюун ухаан, сэтгэлгээний хөгжил, сэтгэхүйн био эрчим хүч болон энергийг судлахтай нягт холбоотой. 1990 онд Монгол оронд болсон ардчилсан өөрчлөлт бол нийгмийн хүрээнд өргөн өөрчлөлтийг авчирсан бөгөөд үүний үр дүнд шинжлэх ухааны судалгааны салбарт шинэ арга барилыг авчирч дэлхий нийтийн голдрилоор явах замыг нээсэн юм. Үүний үр дүнд монголын бөөгийн шашны судалгаа улам өргөжин тэлж олон талаас нь авч үзэх чөлөөт судалгааны үе бий болж, дэлхийн бөө мөргөл, бөөгийн шашны судалгаатай холбогдон нэгдэж, дэлхийн бөө судлаачдын анхаарал хандуулдаг орны нэг болсон билээ. Дэлхий дахины нийт бөө мөргөл судлаачдыг нэгтгэсэн Олон улсын бөө мөргөл судлалын холбоо 1988 онд байгуулагдсан нь монголын бөө мөргөлийн судлалд таатай нөхцөл бүрдэж 1991 онд Сөүл хотноо болсон анхдугаар их хурлаас эхлээд бүх их хуралд нь монголын бөө судлаачид ивэвхтэй оролцож байна. Үүний үрээр 1999 онд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо дэлхийн бөө судлалын V их хурал болж, олон орны бөө судлаач, монголын олон нутгийн бөө, удган нар оролцсон нь бөөгийн уламжлалыг хадгалах, судалгааг шинэ шатанд гаргахад чухал түлхэц болсон юм. Үүний үрээр гадаад, дотоодын эрдэмтэдийн чамбай бүтээлүүд олноор гарлаа. Монголын бөө судлаач Д.Бум-Очирын бичсэнээр бол бөө мөргөл судлал өргөжин хөгжихийн хирээр бөө мөргөлийн уламжлал сэргэн, өөр шашинд орж он удаан жил гадны шашин суртахуун түрэн хөгжсөн Өмнөт Солонгос, Финлянд, Мажар, Төв Азийн Монгол, Саха, Тува, Сибирийн бусад үндэстнүүд ч өөрсдийн уугуул язгуурын шашин, соёл болохоо танин мэдэж байна.(1) Бөө судлаачид бөө мөргөл, бөөгийн шашин хэмээх хоёр ойлголтын талаар маргасаар байна. Бусад шашинтай харьцуулан үзээд сүм дуган, бурхан тахил, бичиж барлаж үлдээсэн судар ном байхгүй учир хэмээн тайлбарлах нь буй. Бөө мөргөл хэмээх ойлголтын хувьд аль ч шашинд мөргөл шүтлэг бий бөгөөд энэ нь тухайн шашны зан үйлийг гүйцэлдүүлэх гол арга хэрэгсэл юм. Бусад шашин бол суурин иргэншилд

---

1. Д.Бум-Очир, Монгол бөөгийн зан үйл, Улаанбаатар, 2002 он, х 7

зохицсон байнгийн шүтээний газартай байдаг бол бөөгийн шашин нь нүүдлийн ахуй амьдралд зохицсон авч явахад эвсээрхэн онгод шүтээнтэй бөгөөд үүнийгээ нүүдэлчдийн гол орон сууц гэрт юмуу байгаль дэлхийд байрлуулах бөгөөд суурин шашны адил шүтлэгийн гол хэрэгсэл болдог. Нөгөө талаар бөөгийн шашин нь хүн төрлөхтний үүсэлтэй нягт холбоотой бөгөөд одоо хүртэл шүтэгдсээр байгаа хийгээд түүний үзэл номлол, зан үйл аман уламжлалаар нэгээс нөгөөд дамжин хадгалагдсаар байгааг нь үзсэн ч сэтгэхүй, онгод, тэнгэрийн энергийн хүчийг бусад шашнаас заримдаа илүүтэйгээр бодитойгоор жолоодон, түүнийг жолоодогч бөө нар онцгой хүч чадлыг эзэмшин олон түмэнд туслан, итгэл үнэмшлийг татаж, бөө мөргөлийн уламжлал, зан үйл, тамлага дуудлага нь аман уламжлалаар үеийн үед тасралтгүй уламжлагдан байгаагаар нь шашин гэж үзэх ёстой юм. Учир нь эрдэмтэдийн судалгаагаар шашин гэдэг нь “муу үйл бүхнийг арилгаад сайн үйл бүхнийг дэлгэрүүлэх сэтгэлийн тэрхүү чадамжийг хэлнэ” (1) хэмээсэнтэй бөөгийн шашины бүх зорилго, үйл бүрэн тохирч байдаг. Мөн Э. Мулдашевийн үзэхээр бол “Шашин гэдэг бол хөгжлөөрөө илүү өмнөх соёл иргэншлүүдийн тухай мэдлэг юм”(2) хэмээснийг бодолцож үзэх юм эртний хүн төрлөхтнүүдийн сэтгэхүйн энерги ашигладаг үеийн эрдэм мэдлэг бөөгийн шашнаар одоо болтол уламжлан хөгжиж байна хэмээн үзэж болно. Бурхны шашин бол хэн хүн олон жил тасралтгүй суралцан сэтгэхүйн энергийг жолоодох дээд төвшинд хүрч агуу энергийн дээд ертөнцтэй холбогдон бурхан болон агуу хүчнийг эзэмшдэг бол бөө уулаасаа байгаль ертөнцийн энергийн хүчийг үе дамжуулан уламжлан эзэмшээд өөрийн энергийн хүч, онгодын энергийн хүчний бөөгнөрөлөөр тусгай зан үйлийн туслажтай буюу тусламжгүй агуу энергийн дээд ертөнцтэй холбогдон энергийн агуу хүчийг эзэмшдэгээрээ адил болон ялгаатай юм. Монголын физикч доктор О.Лхагва ухаарлын дээд төлөв болох нирвааны тухай “Уураг тархи бол 10 нейроноос бүрэлддэг “мангар” бие мөн. Нейрон нь квант шинж төрхт молекулуудаас бүрэлдэнэ. Нейроны аварга сүлжээнд дотоод хүртэхүй мэдрэмжийн энергийг эрчимтэй дайчлахад уураг тархийг хоморголсон гэдрэг тэтгэх гогцоо үйл үүснэ. Тийм давтан шалгарч цэгцрэх тойруу үйл явцын дүнд оюуны доод төлөв чадал арилжиж, дээд гэгээрлийн “квант” чанар төрөл олдог жамыг үгүйсгэх үндэсгүй... Харин хэт дамжуулал бол гадаад нөхцөлөөр залуурдахад дамжуулагчийн “доод” квант төрх төрөл арилжиж, ямарч эсэргүүцэлгүй квант төрхөд шилжиж байгаа юм.

---

1. Д.Давгадорж, “Буддын нууц тарнийн номлол, монгол уламжлал”, Улаанбаатар, 2004, х 16

2. Эрнст Мулдашев, “Хүн мичнээс үүсээгүй”, Улаанбаатар, 2004 он

Хэт дамжуулал нь бодисыг өвч хамарсан нэн хүчтэй хам шинж ноёлоход цэгцэрсэн квант төлөв юм. Гэгээрэлд хүрэхэд уураг тархи “Орчлон” лугаа хамссан квант төлөвт шилжиж, их сүлжээнд амьсан нэгсэх, эвсэх тэрсэхийн үйлчлэлээр мэдээллийг солилцож эхлэнэ. Үйл хувирлын тийм найрааны дүнд л оюуны ухаарал-гэгээрлийн квант төлөв бүрэлддэг гэмээр байна” хэмээсэн бол бөө болон онгодын тухай “бөө онгодын үйлдэл хийхдээ нейроквант цацах буюу шингээж болно. Тэгвэл удмын бөөгийн онгодыг дууддагийн учир юу вэ гэсэн асуулт аяндаа гарна. Ахиад квант физик рүү хандая. Атом бүр олон өнгө гэрэл цацруулж бас шингээдэг. Тэр бүгд нь өөр атомд хэрхэвч үл давтагдах солонгын шугам(спектр) үүсгэнэ. Атом өөрийнхөө туяаг шууд таньж шингээдэг. Энэ бол аливаа квант системд тохиодог нэг ёсны “танихуйн” дархлал гэмээр жам. Тэгэхлээр нейроквант ч бас удам бүрт өвөрмөц бусдынхтай ижилгүй спектр үүсгэдэг байх”(1) хэмээн хоёр шашны энергийн мөн чанарыг квант физикийн онолын үүднээс судлан нилээд бодитой дүгнэн гаргасан байдаг. XX зууны эхэн үеийн Орос, Европийн эрдэмтэн В.Б.Богораз(1910), Михаловский(1892), Валдемар Ёхолсон(1905-1908), Юно Харва(1933) зэрэг түрүү үеийн эрдэмтэд төдийгүй сүүл үеийн Ханс Финдайзен(1957), Вилмос Диосега(1960) зэрэг эрдэмтэд бөө мөргөлийг шашин гэж үзэж байжээ. Сүүлийн үеийн Мажар, Финландын эрдэмтэд ч ингэж үзэх хандлагатай байна. (2) Ийм болохоор шашин гэж үзэх нь үнэнд илүү нийцнэ хэмээн бодно.

Эрдэмтэд судлаачдын хамгийн сүүлийн үеийн тодорхойлолтоор бөө гэдэг бол өөрийн биеэс сүнсээ гаргаж дээд тэнгэр болон доод ертөнцөөр аялан туулдаг, эсвэл өөрийн биедээ бусад сүнс онгодуудыг урин залан оруулдаг чадвар бүхий тусгай мэргэжилтэнүүдийг заан нэрлэдэг байна.(3) Тухайлбал өмнөт Америкт энэ төрлийн зарим мэргэжилтнүүд тусгай бодис (тамхины ханд гэх мэт) хэрэглэн сүнс онгодын орноор аялан туулах юмуу эсвэл онгод сүнсийг биедээ оршуулан цугласан олонтой учир явдлыг хэлэлцдэг байна. Энэ нь бидний тодорхой мэдэж байгаагаар дархад, буриад бөөгийн зан үйлийн үед ажиглагддаг зүйл юм. Ийнхүү биедээ онгодыг оруулж тэдгээрийн энергийн хүчийг зан үйлдээ ашиглах, эсвэл сүнсээ өөрөөс гарган дээд тэнгэр болон орчлон ертөнцийн хүчтэй энергитэй холбогдон ертөнц дахины мэдээлэл болон хэрэгтэй зүйлийг аван буцаж ирэх чадвар бүхий хүнийг бөө гэнэ гэсэн тодорхойлолт ч бас нилээд элбэг байна. Канадын эрдэмтэн Бернارد

---

1. О.Лхагва, “Мөнх тэнгэр ба гэгээрэл”, “Манай Монгол” сэтгүүд, 2002, № 01,02 (13, 14)

2. Д.Бум-Очир, “Монгол бөөгийн зан үйл”, Улаанбаатар, 2002он, х 9

3. Д.Бум-Очир, “Монгол бөөгийн зан үйл”, Улаанбаатар, 2002он, х 8

Саладин Данглар “бөө гэдэг бол шашин мөргөлийн зан үйлийг голлон үйлдэгч бөгөөд хүний ертөнц болон сүнс онгодын ертөнцийн хооронд зуучлагч төдийгүй чанад ертөнцөөр аялж сүнс онгодтой холбоо тогтоох чадвар бүхий нэгэн юм”(1) хэмээн тодорхойлсон байна. Бөө судлалаар 30 жил хөөцөлдөж, дэлхийн 97 оронд 2000 хоног бөө нарын дунд байж, 180 орчим баримтаг кино хийсэн Судан улсын Хартумын их сургуулийн профессор, биосистем болон бөө судлаач Бен Белла Хелга гэгч хатагтай ХБНГУ-ын нэгэн сонинд өгсөн ярилцлагадаа “бөө болох хүнийг ямар ч сургуулиар зориуд бэлтгэж мэргэшүүлдэггүй, бөө нар ихэвчлэн хүн хүнээс онцгой их био энерги биед нь хуримтлагдсан хүмүүс байдаг бөгөөд тэр хүмүүсийн бараг 90 хувь нь эмэгтэй байдаг. Бөө бол шашин гэдгийг хэлж болно”(2) гэх мэтээр бөө болон онгодын мөн чанарыг гаргахыг оролдсон тодорхойлолтууд бий болж байна. Онгодын талаар гагц бөө судлалын хүрээнд анхаарал хандуулж буй бус соёл судлалын, хүн судлалын хүрээнд ч онцгой анхаарал хандуулдаг болж байна. Соёл судлалын бүтээлд онгодын тухай сэтгэл оюуны онцгой түрэлт, онцгой чадвар хэмээн томъёолоод онгодын илрэлийг бөөгийн онгод, уран бүтээлчийн онгод болон ердийн ухамсрын хүрээн дэх онгод хэмээн гурав ангилж үзсэн байдаг. Тэгээд цааш нь “Ерөөс хүмүүн орчлонгийн эрчимт, энергит амьтан болохын хувьдаа түүний сэтгэл оюунд онцгой эрчим хуримтлагдах үе гэж байх агаад тэрхүү эрчмийн хуримтлалын төвшин янз бүр байдгийн хирээр мөн янз бүрийн төвшинд илрэн оршдог хэмээн үздэг байна. Бөөгийн онгод удам дамжин өвлөгддөг, ердийн нөхцөлд онгон шүтээн болон материаллаг хэлбэрээр оршиж, бөө буух үед сүнслэг санаалаг биеийг олж сэргэдэг онцлогтой. Ердийн ухамсрын төвшингийн онгод хүн болгонд байх боловч тэр нь үл ажиглагдам, хаяа нэг сэтгэлийн хөдөлгөөний хэлбэрээр бүүр түүрхэн илрэн орших нь нөгөө хоёр төвшингийн онгодтой харьцуулбал маш хүч султай аж. Онгодын нийтлэг шинж гэвэл аль аль төвшингийн онгод хүмүүний сэтгэл оюуны онцгой түрэлт болохын хувьдаа бүтээн туурвих их хүч өгч энэ ертөнцийн амьдрал, ухамсраас тасарч цэвэр далд ухамсрын хүрээний үйл ажиллагаа болон оршдог байна. Авьяас, онгод хэмээх нь хүмүүний байгалийн эх сурвалжид тулгуурлан үүсч бүтээгдсэн соёлын үнэт зүйлс нийгмийн янз бүрийн үзэгдэл юмстай харилцаанд орохдоо өөр хоорондоо байнгад бие биеэ эрхшээн оршдог байна” (3) хэмээн бусад онгодоос бөөгийн онгод өвөрмөц онцлогтой, ялгаатай

1. Bernard, A. And Spenser, J. 1998, Encyclopedia of Social and Cultural Anthropology, Routledge: London,.

2. “Номер нэг” сонин, 1999 он № 3

3. Ж.Долгорсүрэн, Аман соёлын арга билгийн шүтэлцээ, УБ., 2000 он, х 68-69

болохыг тодорхойлон заасан байна.

Монгол бөөгийн судлал XIX зууны төгсгөл орчмоос эх сууриа тавьж нилээд тооны бүтээл гарсан боловч ихэвчлэн монголчуудын тэнгэр нэрийн шүтлэг, түүнд холбогдох гар бичмэл судруудыг болон бөө мөргөлийн судруудын сан тахилгын судалгаа, бөөгийн яруу найраг, зан үйл, хувцас хэрэглэлийн талаар судалсан судалгаа голлох байр эзэлж байна. Бөө мөргөлийн сүнс онгодын талаар сүүлийн үеийн судалгаануудад анхаарал хандуулж байгаа боловч нэгэн мөр дагнан авч үзсэн бүтээл ховор байна. 1998 онд Монголын эрдэмтэн О.Пүрэв “Монгол бөөгийн шашин” хэмээх ном бичсэн нь хамарсан сэдвийн хүрээ, цуглуулсан баримт сэлт зэрэг аль ч талаасаа монгол бөө мөргөл судлалын түүхэнд өмнө гарч байгаагүй томоохон бүтээлийн тоонд орж байна. Энэ бүтээлдээ анх удаа сүнс онгодын талаар өөрийн дүгнэлтийг зарим нэгэн баримт сэлтээр баталгаажуулан гаргаж тавьсан байна.

Эрдэмтэн О.Пүрэв бөөгийн үүслийн талаар “Хүний бие сэтгэлийн энэхүү чадвар нь эртний хүмүүсийн дундаас бие сэтгэлгээний давуу хөгжилтэй зарим хэсгийг онцгой чадвар бүхий увьдастан болгон төлөвшүүлсэн бөгөөд байгалиас энэ их эрдэм чадлыг эзэмшсэн эдгээр хүмүүс тэнгэр, газар, наран, саран, одон мичид, гал зэрэг байгалийн түг түмэн үзэгдлийг бусдад тайлбарлаж, байгаль хүн хоёрын хоорондох харьцааг үзэл баримтлалынхаа үүднээс зохицуулан зохион байгуулж байлаа. Хүн сүргийн үед бие бялдрын хөгжил ихээхэн ач холбогдолтой байсан бол овгийн байгууллын үед бие бялдрын зэрэгцээгээр оюун сэтгэлгээний хөгжил нь илүү ач холбогдолтой болж, байгалиас заяасан увьдастай, эрдэм чадвартай хүмүүсийг ихээхэн хүндэтгэдэг болжээ”(1) хэмээн өөрийн таамгийг дэвшүүлсэн байна. О.Пүрэв болон бусад эрдэмтэдийн тодорхойлсоноор “сүнс нь эргээд бие хүнд шилждэг бол онгод нь эргээд бие хүнд шилждэггүй гагцхүү бөө болох хүнийг эзэмдэн захирч бөө болгох, нэгэнт бөө болсон хүмүүстээ болон төрөл ургийн хүмүүстээ нөхцдөг” хэмээсэн байна. Энэ талаар доктор С.Дулам Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Тувааны Балжир удганыг судлаад “өвгөд дээдсийн онгод өөрсдөө шилж биед нь эзлэн суусан тэр хүн л бөө болдог байна” хэмээн нотлон бичсэн байна. (2) Энэ нь дээр дурдсан эрдэмтэн О.Лхагвагийн “Атом өөрийнхөө туяаг шууд таньж шингээдэг. Энэ бол аливаа квант системд тохиодог нэг ёсны “ганихуйн” дархлал гэмээр жам.

1. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 1999 он, х 24

2. С.Дулам, “Дархад бөөгийн уламжлал”, Улаанбаатар, 1992 он, х 14

Тэгэхлээр нейроквант ч бас удам бүрт өвөрмөц бусдынхтай ижилгүй спектр үүсгэдэг байх” хэмээн квант физикийн онолын үүднээс бөөгийн онгодын энергийн мөн чанарыг тодорхойлсонтой таарч байна. Тийм ч учраас бөө хүмүүс гэдэг бол орон зай, цаг хугацааны нууцад нэвтэрч, оюун санааны дээд хэмжээнд шилжиж чаддаг, энергийн дээд ертөнцтэй холбогдон сүнс онгодын онцгой энергийг ашиглаж чаддаг болсон хүмүүс байдаг. Бөө нарын бөөлөх зэрэг зан үйл үйлдэж байх үед бөөтэй харьцаж байдаг нэг гол зүйл бол онгод юм. Монгол бөө нарын ойлголтоор бөө нь онгодын улаач, жолооч, бас нартад байдаг элч төлөөлөгч, онгодоос хүн рүү, хүнээс онгод руу хэл залгуулдаг хэлмэрч учир онгод нь энэ хүнийхээ урилга дуудлаганд яаравчлан бүр заримдаа урьж дуудаагүй байхад нь юм уу эсвэл өөр онгодын өмнүүр дугаар эвдэн орж ирэх явдал байдаг байна. Ингэж орж ирэхдээ бөөгийн онгодын унаа болсон хуур юмуу хэнгэрэгийн дуугаар хөлөглөн тамлаг дуудлагаар хүчжин орж ирдэг байна. Тэгэхээр дууны энергийн давтамжийн хүч онгодын энергийг даллан дуудах, тухайн бөөгийн өөрийн энергитэй нэгдэн хүчжихэд онцгой үүрэгтэй байдаг байна. Тийм болохоор хэл хуургүй юмуу хэнгэрэггүй бөө нэг ч байдаггүй. Бөөд удмын онгодоос гадна ойр тойрны онгодууд орж ирдэг байна. Хүчтэй бөөд хэдэн ч онгод орж ирж чаддаг байна. 2005 оны зун Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Соёо багийн бөө Доржийг бөөлөх үед 7 онгод орж ирлээ хэмээн хэлж байсан. 2004 оны зун Хөвсгөл нуурийн хөвөөнд бөөлсөн 70 гаруй настай Долгор удганд 11 онгод орж ирлээ хэмээж байсан. Энэ нь бөө хүн тухайн зан үйлээрээ асар их мэдээлэл хүчийг агуулсан сүнс онгодын энергийн дээд ертөнц буюу неороквантын урсгалтай шууд холбогдож байна гэсэн үг юм. Агуу эрдэмийн мөн чанарт хүрсэн лам хүнд ийм чанар байдаг нь энэ хоёр шашны нийтлэг чанар юм. Үүний хажуугаар онгодын энергийн агуу хүчний хуримтлал болдог учраас нэг нутагт хоёр буюу түүнээс дээш тооны бөө нар нэгэн цагт зэрэгцэн бөөлөх явдал цээртэй хэмээн харын бөө нар үздэг байна. Дээр дурдсан Долгор удганыг бөөлөхөд Батбаяр удган нэг газар нэгэн цагт хориод метрийн зайтай бөөлсөн билээ. Тэгээд тэндээсээ нутгаараа ороод буцаж явахдаа Эрдэнэт Дарханы зам дээр машин нь онхолдож гэр бүлийнх нь амьд гараад өөрөө нас барсан байдаг.

Тэр ч байтугай бөөг зарим үед бөөлүүлэхгүй зогсоох, эх нутаг гал голомтноосоо олон хоног сараар төрийн бус ажил эрхлэн хол явуулахгүй байж, хоног хугацаа зааж дуудах, уриад залаад байхад нь ирэхгүй болчих, бөөгийн хувийн амьдралд зөвлөгөө өгөх, суух нутаг заах, бөө болон тэдний ураг төрлийн хүмүүсээ элдэв аюул барцадаас зайлуулах, хар

муу санаатны эсрэг турхирагдан очиж хорлол үйлдэх зэргээр бөө онгод хоёр янз бүрийн хэлбэрээр харьцаж байдаг. Энэ бүхэн нь ердийн үзэгдэл мэт боловч бөөгийн шашны нэг танигдаагүй нууц юм.(1)

Бөө хүн онгодын хүчээр өөрийгөө болон бусдыг эмчилдэг байна. Энэ Онгодын энергийн хүчээр бусдын болон өөрийн энергийн тэнцвэрийн бий болгох өвчин үүсгэгч сөрөг энергийг хөөн зайлуулж чаддаг байна. Маанжриг ясны Дашийн Дамба \1938 онд хэлмэгдсэн\ заарин 1920-иод оны үед өөрөө өвчтэй байгаад бөөлөхдөө Балдангийн Авир гэгчийн сэтгэлийг жолоодон өөрийгөө цахиур буугаар буудуулсан боловч үхсэнгүй, харин цустай идээ бээрээр бөөлжөөд өвчин нь эдгэрсэн байна. Энэ эмчлэх чадвар нь ойр холын зайнаас хамаардаггүй байна. 2003 онд Долгорын Басбиш хэмээх хүний бие их муудаж эмч нар үзээд их хэцүү болсон байна гэхэд найз нөхөд нь аймгийн төвийн захад шахуу бөөд очиж хэлэхэд тэр хүн үзээд шууд бөөлж бөөлөх дуугий утсаар сонсож байсан байна. Тэгээд тэр хүн удалгүй бие тэнхэрч эдгэсэн байна. Улаанбаатарт байсан хүн Москвад байгаа хүүгийнх нь бие муудахад бөөд очиж бөөлүүлээд орой нь утасдахад бие нь сайжирсан байсан гэдэг. Энэ нь асар их мэдээлэл, хурд, хүч чадлыг агуулсан онгодын энергийн гүйдэл нь тэнгэрээр агаараар явдаг учир хүрэх газраа шууд хүрдэгтэй холбоотой байна. Бөөлөөгүй байхад ч бөө хүнд мэдээлэл өгч, тусалж байдаг. Тувааны Балжир удган 1994 онд “Онгод гэдэг хэзээд сэргэлэн, хүчтэй... дэлхийг хэрэн явдаг тул дэлхийн байдал болон бусад зүйлийн тухай олон зүйл хэлж өндөр насалсан намайг их ядраадаг” (2) хэмээн хэлж байжээ.

Онгодын энергийн хүчээр ид шидийг үзүүлэх тэсгим хүйтэнд хөлдөхгүй байх, жигүүртэн шувуу, ан амьтан болж хувирах үйлийг хийдэг байна. Цагаан хуулар ясны Шаравын Дашдаваа (1899-1936) удган 1930 оны 1-р сарын эхээр идэр есийн хүйтэнд шөнө бөөлж байгаад тооноороо (толгой, хөл нүцгэн, дан даавуун дотуур хувцастай) гарч долоо хоног хээр яваад ирэхдээ хасах 40-өөд хэм хүртэл хүйтэрдэг энэ нутагт гар хуруу нь огт хайрагдаагүй байсан гэдэг. Дэлдэн Мэнд гэдэг хулгай хийгээд баригдаж байгаагүй, худлаа хэлээд автаж байгаагүй, арван гурван арвас, хорин гурван ховстой сүрхий хүн байсан гэдэг. Мэндийг баривчилж байцаахаар хошуу тамгийн газраас элч тахрууд ирээд аваад явахад, түүний өмсөж явдаг хар дах нь Мэнд болж очдог байж. Нэг удаа тамгийн газар Мэндийг

---

1. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 1999 он, х 24

2. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 1999 он, х 147

айхтар ширүүн банздуулж, орь дуу тавьж байхыг харсан нэг хүн тэр дор нь ар гэрийнхэнд нь хэлэхээр яаран давхисаар хүрч очтол, Мэнд хоймортоо хэзээний янзаараа цайгаа уугаад сууж байж. “Үгүй, энэ чинь, сая таныг банздуулж байхыг хараад энд хэлэхээр ирсэн чинь та цайгаа уугаад сууж байдаг” гэсэнд “Аа тамгийн газраас баривчлах болоол, ирэхлээр нь тэдэнд өөрийгөө болгоод, өмсөж явсан өнөө муу дахаа өгөөд явуулчихдаг юм. Тэд ч авч ханадаггүй, би ч өгч бардаггүй болсон юм аа. Харин тэр муу дах маань банздуулж шаахайдуулсаар байгаад, танаг тамтаг болж дуусах нь шиг байна” гэж сууж. Ийм нэг арвастай шидтэй зайран байсан байна. Богдын төрийн үед Багваа удган гэж дархадад байжээ. Хүрэлдэй ганц хүүтэй юмсанж. Тэр хүү нь эхийнхээ онгодоор цуцалж(шилжүүлж) бөө болжээ. Давагдахгүй сүрхий зайран гарчээ. Түүндээ аархаад хулгай хийдэг болжээ. Адуу хөөгөөд л ирдэг, эзэн нь байдаггүй, харин нэг шувуу л нисэж харагддаг болж. Түүнийг барихаар нэг хятад шинжээчтэй салаа цэрэг гарч гэнэ. Дархад нутагт Хун тасын хад ч гэдэг, Бошлой хад ч гэдэг, түүн дээр нэг бүргэд шувуу сууж байхыг хараад, өнөө хятад шинжээч “Хун цомтой энэ нэг хадан дээр сууж байгаа тэр нэг шувууг харваад орхи” гэсэнд харваад орхиж. Өрөөсөн далавчий нь сэт харваад сум нь гартал, хүн дуу алдах шиг болоод, өнөө бүргэд ёроол руу унаад ирж гэнэ. Барьж аваачаад тамгийн газар байцааж асуугаад, хэргий нь хүлээлгэж, хуулийн шар бичиг уншиж, цаазаар авах болж дээ. Тэгээд хороохоор хүзүүн дээр нь илдээр цавчиж орхитол илдийн ир нь гэлрээд эс дааж гэнэ. Ингээд хороож эс чадсанд, ээжид нь очиж хэрэг явдлыг хэлсэнд, эх нь “Миний хүү алдаа хийсэн нь үнэн. Шидтэй нь үнэн. Гэвч төрийн цаазыг давах ёсгүй нь бас үнэн.” Ийм болохоор 37 нас хүртэл хүүхэд гаргаагүй эмийн өмдийг толгойд нь углаад, шар жингэрийн сэмжээр дээрээс нь бүтээгээд цавчвал, сахисан тэнгэр, хуягласан юм нь гутаад, эр биеэс нь зайлж, энэ хуулийн дор орох байлгүй дээ. Гэвч би ганц хүүгийнхээ амийг нэхэх биш үү? гэжээ. Тэр хэлсэн ёсоор нь бүгдийг хийгээд, цавчаад орхитол, хүүгийнх нь толгой ч унаад ирж, цээжнээс нь нэг хөхөө гараад, донгодоод нисээд явчихсан хэмээсэн домог байдаг.(1)

Бөө хүн онгодын энергийн хүчээр, хаяж гэсэн зүйл, алдуул мал, олдохгүй эрэл зэргийг шууд олдог байна. Шаравын Дашдаваа удган 1919 оны намар нэг удаа бөөлөх гэж байхад Шарав-Осор гэдэг лам удганд хандаж би хөөргөө гээчихээд хэдэн сар боллоо. Хөөргий минь олж өгнө үү гэхэд удган бөөлж буугаад хөөргийг тань би оллоо. Авчрах гэсэн боловч өргөж даасангүй, харин тамхий чинь асгачихлаа, наран ургах зүгт онгон тахилгатай хоёр

---

1. Л.Хүрэлбаатар, “Дуун утгын яруу зохист”, Улаанбаатар, 2005 он, х 131-133



уулын завсарт орших багахан хөндийд, нэгэн урсгал усны зүүн талд өтгөн ургасан өвсөн дотор хөөрөг тань байна. Би дэргэд нь тэмдэг тавьчихлаа. Малын хөлөөр гатлагдахаас өмнө маргааш өглөө эрт очиж аваарай гэжээ. Шарав-Осор лам удганы хэлснээр хөөргөө гээсэн газрын баримжааг мэдэж маргааш нь очтол Намнан, Тогос хоёр уулын хооронд (Тогосын тал хэмээх хөндийд) Тогосын горхины зүүн гар талд нэгэн шарилжин бутны оройд хуучивтар самбай хадаг уясан байв. Тавьсан тэмдэг нь энэ юм байх гэж бодоод мориноосоо буутал тэр хавьд бага гэрийн буурийн чинээ газар өвс нь налчихсан, хөөрөг нь толгойноосоо салчихсан, тамхийг нь цувуулаад асгачихсан байж гэнэ.(1) Мөн Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын харьяат хар дархад ясны Цэвээний Аюур\1898-1948\ зайран тун сүрхий ид шидтэй бөө байжээ. 1944 оны намар Балбирагт суудаг Гунагарын Жамбал гэгч айлд бөөлөх гэж байтал нь Дотоод явдлын яамны хэсгийн төлөөлөгч Лувсан гэгч Сандаг, Балдан нарын хамт ирж, бид таныг яах ч үгүй. Хатгалын дунд сургуулиас манайхны гурван хүүхэд оргоод олдохгүй болчихлоо. Цасан шуурганд төөрчих шиг боллоо. Үзэж өг гэхэд заарин үзээд "Уржуулын даваа шиг байна. Нэгэн их цастай давааны өвөрт гурвуулаа өөд болчихсон байна. Сандаг та түрүүлж тэднийг үзэх юм байна. Айж цочиж, уйлж унжиж болохгүй. Тэгвэл өөрт чинь муу юм болох нь ээ" гэтэл Сандаг өөрийнх нь хүүхдийн цогцос эхлээд тааралдахаар нь тэрээр ихэд цочиж, уйлж сүйд болжээ. Түүнээс хойш удалгүй Сандаг нь сэтгэцийн өвчтэй, бас хэлгүй болж яваад өнгөрсөн гэдэг. (2)

Онгодтой нөхцсөн бөө хүн онгодынхоо тусламжтайгаар далдыг харах, алс холын зайд сэм ярилцсаныг сонсох, ховс хийх, энгийн нөхцөлд үнэр үл мэдэгдэх юмсын үнэрийг үнэрлэх зэрэг эрдэм чадварыг эзэмшдэгээрээ жирийн нэгэн мэргэч төлөгч үзмэрчээс давуу талтай.(3) Түүнээс гадна онгод нь хэрэгтэй цагт бөө, удгандаа шууд туслах явдал байдаг байна. Янжив зайрангийнхний удам Төшөөрэй удган 1990-ээд оны сүүлч болтол Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Соёо багийн нутагт амьдран сууж нутгийн олонд тусалдаг байсан билээ. Олон жил айл саахалт явсан маарамба Долгорын Басбиш хэмээх хүнд хуучилахдаа "надад тийрэн нөхцчихсэн юм. Тэгэхдээ муу юм хийхгүй л дээ. Харин ч надад тусалж байдаг юм" гэдэг байжээ. 1990-ээд оны эхээр монгол орон даяар цай тасарсан билээ. Тэр үед Төшөөрэй удган бас цайгаар тасарч хөрш Басбишийнхээс жаахан

---

1. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 1999 он, х 137

2. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 1999 он, х 138

3. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 1999 он, х 147

цай зээлж авчээ. Тэгэхэд зусланд бууж байсан үе тул Басбишийн ажилсаг хүүхдүүд Төшөөрэйг нэг салж унах шахсан ханыг шинэ хана хийж солихоор гэрийг нь буулгаж байжээ. Түүний орны дээд талд хоёр авдрын тушаа хүргэн нь гэр буулгаж байснаа “Ээж та цайгүй цайгүй гээд айлаас цай зээлээд байсан. Танд цай байсан л байна шүү дээ” гээд хоёр авдрын хоорондох гурвалжин зайнаас бүв бүтэн, шинэ дугуй булантай цай гаргаж иржээ. Төшөөрэй ийм тийм гэж юм хэлсэнгүй дуугүй авч, адис хүртээд далд хийжээ. Дараа нь 1990-ээд оны дундуур өвөл цагаан сар дөхөж байхад Төшөөрэй “Одоохон цагаан сар боллоо. Нутгийн хүүхдүүдэд хэдэн чихэртэй хамт авч өгөх бутархай төгрөггүй яана даа” хэмээн бодож байжээ. Нэг өдөр хүргэнийдээ орой болтол байгаад гэртээ орж ирвэл бурхан тахилаа тавьсан авдрынх нь дээр зөндөө бутархай төгрөг байжээ. Тэгээд би ер нь буруу хий юм харсан байх гэж бодоод охиноо дууджээ. Охиных нь хэдэн алхмын цаана тул дороо л гүйгээд ороод иржээ. Төшөөрэй түүнд “чи тэр бурхны авдар дээр юм байна уу? Хараад орхи доо” хэмээн хэлжээ. Охин нь харснаа “Ээж та бутархай төгрөггүй гээд байсан, танд зөндөө л байна шүү дээ” гэжээ. Тэгээд тэр хоёр тоолж үзвэл дандаа 5 төгрөгөөр нийт 145 төгрөг байсан бөгөөд цагаан сараар хүүхэд багачуудад хүссэн бэлгээ өгч их сайхан өнгөрөөжээ. Төшөөрэй удганыг нутгийн хүмүүс үзүүлэх засуулах юмаа хэлээгүй байхад өөрөө хэлээд байдаг, бодол уншдаг хүн байсан хэмээн хэлдэг байна. Соёо багийн малчин Цогхүү нэг үхэрээ алдаад Төшөөрөйд үзүүлэхээр очжээ. Тэгэхдээ замын турш Ринчэн л авсан гэж бодсоор очоод үзүүлж байхдаа ч бас тэгэж бодож байжээ. Төшөөрэй үзээд “За Ринчэн авсан байна. Өнөө шөнө багийн төвийн байшингаасаа гаргах гэж байна” гэж хэлжээ. Тэгээд Цогхүү орой түүний байшинг очиж үл мэдэг завсраар харвал үнэхээр байшингийн гол дунд давуугаар бүтээсэн нэг юм байжээ. Тэгээд хажуу дахь жалганд очиж нуугдаад “за шөнө махаа авахаар ирэхээр нь барьж авна” хэмээн бодон хүлээжээ. Хүлээсээр байтал үүр цайж, өглөө болжээ. Тэгээд дахиад Төшөөрэйг гэрт давхиж хүрээд, ортол урдаас нь “чи золиг өчигдөр өөрөө тэгэж бодож ирсэн хүн байна. Би чиний бодлыг уншаад буруу хэлчихжээ. Чамайг явсны дараа үзсэн чинь тэгэж гарч байна. Үхэр чинь энэ хойт голын цаана айлын үхэр дотор байна. Одоо очиж ав” хэмээжээ. Тэгээд яваад очвол үхэр нь үнэхээр айлын үхэр дотор байжээ

Монгол бөө нар онгодыг нүдэнд үл үзэгдэгч “хий ухаар бие” хэмээн үздэг учраас тэр нь ямар нэгэн жинтэй, тэгэхдээ бүр хүнд жинтэй байдаг хэмээн үздэг болно. Онгод өөрөө ийм их жинтэй байтлаа юм өргөхдөө өргөх юмсын чанараас шалтгаалан маш

ялгавартай байдаг гэнэ. Тухайлбал алт, мөнгө, оюу, номин, шүр зэрэг есөн эрдэнийн зүйл бүхий үнэт эдлэлийг өргөж даахгүй. XIX зууны үед Засагт хан аймгийн Ёст бээсийн хошууны “дархан бөө” Цэнд зайран гэгчийг хошуу ноён нь дагуулж манж Чин улсын хаанд бараалхдаг байжээ. Нэг удаа ийнхүү Бээжинд очоод эзэн хаанд бараалхахаасаа 3 хоногийн өмнө ноёнтон, одоогийн Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын нутагт байсан өргөөндөө ямба ёслолд өмсдөг хантаазаа мартсанаа мэдээд Цэнд зайранд хэлтэл тэрээр тал хэнгэргээ явуулж ганцхан шөнийн дотор хантаазыг нь авчрахдаа мөнгөн товчнуудыг нь даагаагүй учир тасдаж хаяад авч одсон гэдэг.(1) Дээр дурдсан Дашдаваа удган эрдэнийн чулуун хөөргийг даагаагүй нь үүний нотолгоо юм. Гэхдээ цай, мөнгө, хантааз зэргийг дааж байсныг бодоход онгодын энергийн хүч дэлхий датах хүчний энергээс илүү хүчээр цаг хугацааны орон зайг хоромхон хугацаанд туулан биет зүйлийг зөөдөг болтой байна.

Онгод нь тэдний ураг төрлийн хүмүүсээ элдэв аюул барцадаас зайлуулах, хар муу санаатны эсрэг турхирагдан очиж хорлол үйлдэх зэрэг сөрөг энергийн хар хүчийг бас агуулдаг байна. Төшөөрэй удганы дүү бол Жумбуу өвгөн юм. Биднийг 1990–ээд оны эхээр анх танилцаж байхад хань нь өнгөрөөд удаагүй, эмэгтэй нь гуравтай, эрэгтэй нь тавтай хоёр хөөрхөн хүүхэдтэйгээ үлдсэн байсан билээ. Өнөө үзэхэд ханхар сайхан залуус болсон байна. Тэднийх Хөгийн голын цаана Ивэдийн голын наахан жилийн дөрвөн улиралд ойр ойрхон газар нүүдэллэн ганц гэрээр хэдэн малтайгаа нутаглана. Мал нь жилийн жилд өнгө зүс сайтай онд орох бөгөөд хэдийгээр боохой элбэг ч малд нь тэр болгон хээрийн амьтан орохгүй. Ханиа алдаж ганцаардсанаас тэрүү хоёр хүүхдээ сургуульд явуулалгүй өөрөө бичиг үсэг зааж өгөөд ном, сонин захьж аваад түүнээ байнга уншуулж боловсрол мэдлэгийг нь дээшлүүлж байдаг байна. Тэгтэл 2000 оны эхээр Цагдаагийн академ төгссөн шинэхэн дэслэгч Рэнчинлхүмбэ суманд очжээ. Тэгээд л яльтай, ялигүй хэрэгтэй олон хүнийг баривчлан авч машин дүүргээд Мөрөнгийн төв цагдан сэргийлэх ангид ачуулсан байна. Тэдгээр хүмүүсийн дотор Жумбуу өвгөнийг авгайх нь үхэлд буруутган ачжээ. Жумбуу өвгөн “би хоёр жаахан хүүхэдтэй. Намайг үгүйд тэд маань хэцүүдэнэ. Тэгээд ч тэр үеийн хэсгийн төлөөлөгч үнэн мөний нь олсон шүү дээ. Намайг битгий ачаач” хэмээн гуйжээ. Хэрэг илрүүлэх өвчин тусч залуу насны халуун ааг омог нь буцалсан шинэ төлөөлөгч түүний үгийг сонссонгүй ачжээ. Тэгэхэд нь “За яахав. Чамд л муу юм болох байх даа” хэмээн хэлээд явжээ. Аймаг ороод удалгүй үнэн мөнөө олж буцаж иржээ. Тэр явдлаас

хойш нэг их удалгүй тэр хэсгийн төлөөлөгч залуугийн төрсөн дүү нь гэнэт нас баржээ. Тэгээд аав, ээж нь миний хүү буруу зүйл хийж байгаагаас ийм боллоо хэмээгээд аймгийн төвд шилжүүлж авчирчээ. Шилжиж ирээд удалгүй нэг өдөр эхнэрээ сундлан мотоциклтэй давхиж яваад гудамны цаанаас гарч ирсэн ачааны том машины хажуу руу шааж ороод өрөө газар дээрээ нас барж, эхнэр нь эмнэлэгт олон хоног хэвтэж байж нэг юм мэнд гарсан байна. Тэгэхээр тэдний удмынхныг даасан тэнгэр буюу онгод нь өмөөрсөн хэрэг юм. Социализмын үед ч нэр нь мандаж олон удаа баригдаж шоронд орж байсан Дамдин зайран бас эдний хамаатан бөгөөд авга минь байсан юм хэмээн Жумбуу гуай хуучилж байсан билээ. Нэг ааш муутай эхнэр, удган хүнтэй хэрэлдээд элдвээр харааж зүхэн занаж, чамайг хорлуулна хэмээн зангаад явжээ. Тэр удган тэр хүнтэй бараг хэрэлдээгүй шахуу бөгөөд гэртээ ирээд онгоддоо залбирчихаад унтаад өгчээ. Дараа нь хэдэн хоногийн дараа тэр ааштай эхнэрийн хараал өөрт нь хүрч хүүхдээ алдаад бие нь муудаж хэцүү байдалд орсон байна. Үүнийг өгүүлэгч нь тэр удган байсан бөгөөд тэр, тэр хүний эсрэг юу ч хийгээгүй гэсэн бөгөөд удганы онгод түүнийг өмөөрч үүнийг хийсэн хэрэг юм. Тэр эмэгтэй тэр хүнийг удган гэдгийг бас мэддэгүй байсан хэрэг юм. Эцэст нь тэр эмэгтэй бөөд хандаж бөө түүнд үүнийг аргалж чадах тийм нэртэй бөөд оч хэмээн явуулжээ. Тэр хүн асууж сурсаар хүрээд иртэл тэр бөө нь өнөөх түүний занан зүхэж элдвээр харааж занасан тэр эмэгтэй байсан гэдэг. Тэгээд шалдаа бууж уучлал гуйж, аргалуулснаар зүгээр болсон байна. Нэг саваагүй нөхөр бөөгийн өрөөнд орж ирээд зөвшөөрөл авалгүй онгодынх нь зургийг шууд авсан бөгөөд зураг авахаар товчлуураа дартал шар гээд авпарат нь эвдэрч дахин огт ажиллахгүй болсон байна. Энэ нь таагүй зүйлд онгодын бодит хүч үйлчилж байгааг харуулж байгаа юм. Учир нь бөөгийн дургуйцсан сэтгэлийг онгодын хүч шууд мэдрэн хамгаалах арга хэмжээ авсан хэрэг юм. 1970-аад оны эхээр цэргийн алба 3 жил байхад хамт алба хаасан оны цэрэг маань халагдаад аймагтаа очингуут цагдаа болсон билээ. Тэгээд 90-ээд оны эхээр тааралдахад энгийн хувцастай тааралдаад ийн хуучилсан билээ. 80-аад оны сүүлээр нэг ялигүй хэргийн улмаас нэг айлд, нэг цагдаагийн хамт нэгжлэг хийсэн байна. Тэгэхэд нэг сайхан ангийн хутга байсан бөгөөд тэр хоёр хууль дүрэмд таарахгүй ч хүйтэн зэвсэг зориуд хадгалсан хэмээн далайлгаж түүнийг хураан авчээ. Хутгаа хураалгахдаа бөө удмаас минь дамжиж ирсэн хутга юм байгаа юм. Та нар араа, хойчоо бодсон юм байгаа биз хэмээн сануулсан байна. Тэр үед тэр хоёр цагдаа олон жил шашингүйн үзлээр номнуулсан тул чиний тэр бөө удган тэндээ байдаг юм байгаа биз.

Түүнээс чинь айхгүй ухааны юм ярьсан байна. Тэгээд жилийн дараа хутгийг нь хувьдаа авч хэрэглэж байсан манай оны цэрэг хүндээр шарлаж арай л мажийгаагүй байна. Арайхийн эдгэж гарч ирээд байтал дахин шарлаж бас их хүндэрсэн байна. Аргагүй болоод л үзүүлж, харуултал хийсэн явдлынх тухай ярьж тэр юмы нь нэн даруй буцааж уучлал гуйх хэрэгтэй хэмээсэн байна. Тэгээд ёсоор болгож бас дээр нь уучлал гуйж, өргөл барьц өгч байж тэр хүний удмын онгодыг тайтгаруулсан болтой нэг юм илааршиж босч иржээ. Тэгээд цагдаагаас шууд гарч энгийн ажил хийх болсон доо хэмээн ярьсан юм.

Монгол нутгийн газар болгон бөө байхгүй бөгөөд эрт цагийн овог аймгийн ёс заншил, хэл аялгууг хадгалсан зах хязгаар нутагт бөө болон бөөгийн онгод элбэг байна. Иймээс бөөгийн шашинтнууд онгодыг тухай бүртээ тодорхой байрлалтай байдаг хэмээн үздэг бөгөөд энэ байрлал нь тэр онгодын урьд хүн байх үеийн гэрээслэлээр буюу хэрэв гэрээслэж амжаагүй бол аль нэг бөөгийн зааснаар тогтоосон нутаг нь юм. Энэ л нутгаар тухайн онгодыг энэ газрын “аав”, тэр газрыг “ээж” гэх мэт хүйсээр нь, газар нутгаар нь нэрлэдэг. Өөрөөр хэлбэл онгодын байрлал (нутаг) бол тэр онгодын хүн байсан үеийн бөөгийн нутаг байдаг. Тийм ч учраас бөө нар болон онгодын байрлалыг эртний овог аймгуудын байршил, үе үеийн хүн амын шилжин нүүх хөдөлгөөний үндсэн чиг баримжаа хэмээн тодорхойлдог болно.(1) Ийм болохоор онгод болон бөөтэй газрын хүмүүс хүүхдүүдийнхээ амь нас, эрүүл мэнд, сайн сайхныг яс угсаа, гарал үүсэл үл харгалзан аль нэг нөлөө ихтэй (хүчтэй) онгодод даатган сахиулдаг. Хүүхдүүдээрээ сахиус онгодод нь үйлчлүүлэх зэргээр тэднийг багаас нь (онгодод) дасгаж, хүмүүжүүлдэг байсан байна.(2)

Үүнээс гадна онгодыг эцэг, эх бөө нар нь хөвгүүн, охин бөөдөө, багш бөө шавь бөөдөө өмчинд өгч, авч тэр ч байтугай хүүдээ зээлээр өгч болдог зүйл хэмээн бөө нар үздэг нь тодорхой бодит энергийн хүч байгааг харуулдаг байна. Харын бөөгийн шашинтнууд онгодыг лусаас гаралтай онгод, сүнснээс гаралтай онгод хэмээн хоёр ангилж үздэг нь удмын бөөгийн сүнслэг онгодын энергийн хүч, өөр бөөгийн байгальд онголсон онгодын энергийн хүч, байгалийн энергийн хүчтэй нэгдэн нийлсний хэлбэр хоёрыг хэлж буй хэрэг юм. Тийм болохоор бөөд онгод орно гэдгийг бөө нар өөрсдөө олон жилийн өмнө өөд болсон бөө хүмүүстэй уулзана гэсэн үг юм гэж үздэг байна.(3)

---

1. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 1999 он, х 140

2. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 1999 он, х 140

3. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 1999 он, х 144

Бөө нарт ийнхүү онгодын энергийн нэгдмэл цул хүч тусалдаг учраас тэд илбийн ухаанаар хүний нүдний харааг шалгаж, сэтгэлийг хувиргаж, бас гайхамшигт ид шидийг үзүүлдэг байжээ. Онгод нь бөө болох хүнийг эзэмдэн авч түүний биед нэгэнт нөхцсөнөөс хойш тийнхүү учирсан хүнтэйгээ байнгын холбоотой байж, түүнийг элдэв мэдээллээр хангаж байдаг. Өөрөөр хэлбэл бөө хүн тус бүрийг тойрсон тэр бөөд төвтэй онгодын нэгэн бичил орчин бүрэлддэг. Онгод нь энэ мэдээллээ бөөлөх зэрэг ямар нэгэн зан үйл үйлдэж байгаа нөхцөлд ч, энгийн байдалд ч бөөд байнга өгч, түүний оюун санаанд байнга нөлөөлж, асуултанд тодорхой хариу өгч байдаг. Тийм учраас жинхэнэ сайн бөө хүн элдэв мэргэ төлгө, илбэ ховсийн үйлдэл хийлгүйгээр асуудлыг шууд шийдвэрлэж оношийг нь шууд тавьж чаддаг оршино.

Тахилга хийх, бөөлөх үед бөөгийн чимэглэсэн өргөл мод өөрөө хугарсан, бөөлөхдөө хэрэглэх өргөлийн моднуудыг толиндоо шившиж, уулнаас онгодоороо авчруулаад онгодоороо залуулсан, хэрэгцээтэй хэмээн үзсэн хүнийхээ сэтгэл санааг уяруулж, хол ойрын зайнаас түүнд нөлөөлж байсан, далдыг харж ямар нэгэн мэдээг урьдчилан хэлж, өнгөрсөн явдлыг мэдээлж, гээсэн зүйлийг олох буюу байгаа газрыг нь тогтоогоод тэнд д нь тэмдэг тавих, алдуул малын зүс, байгаа газрын төрх байдлыг тодорхойлох, бөөлж байхдаа буудуулчихаад үхээгүй, идэр есийн хүйтэнд олон хоног хээр нүцгэн шахуу яваад огт хайрагдаагүй байсан, ноёныхоо хувцсыг хол нутгаасаа нэг шөнийн дотор аваад ирсэн, цай, мөнгө авчирч өгөх, өөр бусад амьтан болон хувирах, хүнээс гарамгүй хүчээр өндөрт үсрэн хөөрөх, асаасан түүдгийн дээгүүр суугаагаараа наана цаана нь гарах зэрэг жинхэнэ “онгод”-той, ид шидтэй холбоотой эдгээр жишээ, баримт бол онгодын энергийн онцгой хүч чадлын илрэл бөгөөд хүний оюун ухааны энергийн агуу хүч, байгаль ертөнцийн энергийн тайлагдаагүй нууцсын нэг хэсэг юм. Энэ талаар эрдэмтэн О.Пүрэв “онгод гэгч нь лус савдагийн эзэдтэй нэгдсэн талийгаач дээдсийн сүнсний бие, хүнд нөхцсөний нэг хэлбэр бололтой. Онгод нь лус савдагийн эзэд болон сүнсний нэг адил нүдэнд үл үзэгдэнэ. Тэрээр бодит бололцоо нь бүрэлдсэн бие хүний оюун санааг үе үе эзэмдэн авч, түр зуур өөрчлөн, түүний бүх анхаарлыг ямар нэгэн хийсвэр төсөөллийн (байгаль дээр байхгүй) оронд төвлөрүүлэн жолоодож чаддаг хий ухаар зүйл, өөрөөр хэлбэл хүний биед буюу орчин тойронд хуримтлагдсан амин гүйдэл (биоток), хүний уураг тархины эд эсүүдэд нөлөөлсөн өндөр нам янз бүрийн хүчдэл бүхий эрчим хүч бололтой”(1) хэмээн

---

1. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 1999 он, х 148-149

тодорхойлсон нь үнэнд нилээд дөхүү очиж байна.

Тахилгад бэлтгэж байх үедээ бөө мах юмуу махан хоол идэхийг цээрлэн хөнгөн маягаар хооллохын дээр, үхээрийн газраар очих, хүний шарилд ойртох, шарилд ойртсон хүнтэй уулзах, хэрүүл зодоон хийх, хараал хэлэх зэргээс ихэд болгоомжлон биеэн аль болох ариун байлгах ёстой байдаг байна. (1) Ер нь бөөгийн үзэхээр бол “онгод” үзэгдэх, баригдах биегүй мөртлөө өөрийнх нь биеэс цагийн цагт уяатай байх тул бие цогцосоо цэвэрхэн сайхнаар авч явбал төдийчинээ их “дуртай” байдаг ажээ.(2) Бусдад хорлолтой үйл хийх, эсвэл онгодоо ёс журмаар нь тахиж бөөлөхгүй, өөрийн онгодыг үл тоомсорлон илүү хүчтэй онгодыг дуудах, бохир заваан байдалтай байж сөрөг энерги цуглуулах зэрэгт бөөгийн онгод нүүр буруулж зайлан одоод ирэхгүй болох явдал байдаг байна. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Нэргүй зайран Чингисийн онгодыг дуудсанаас болж онгод нь нүүр буруулж орохгүй болоод нилээд хэдэн жил болсон байна. Бурхны шашинд нирвааны төлөвийг олоход бие, хэл, сэтгэлийн гэм бүхнийг арилгаж асар их эерэг энергийг хуримтлуулж бясалгалын дээдэд хүрснээр оюуны шидийг олж, энергийн дээд ертөнцтэй холбогдож чаддаг хийгээд нямба хийсэн хүмүүс голдуу гэгээнтэн болдог явдал болон онгодын улаач болсон бөөг бие, хэл, сэтгэлээр цэвэр ариун байлгах энэ хоёр бол энергийн дээд ертөнцөд хүрэх арга нь нэг л байна гэсэн үг юм.

### Ном зүй

1. Д.Бум-Очир, Монгол бөөгийн зан үйл, Улаанбаатар, 2002 он
2. Bernard, A. And Spenser, J. 1998, Encyclopedia of Social and Cultural Anthropology, Routledge: London,.
3. Д.Давгадорж, “Буддын нууц тарнийн номлол, монгол уламжлал”, Улаанбаатар, 2004 он
4. Ж.Долгорсүрэн, “Аман соёлын арга билгийн шүтэлцээ”, УБ., 2000 он
5. С.Дулам, “Дархад бөөгийн уламжлал”, Улаанбаатар, 1992 он
6. Caroline Humphrey with Urgunge Onon, “Shamanas and Elders”, Oxford, 2003
7. John Lee Maddox, “Shamans and Shamanism”, New York, 2003
8. О.Лхагва, “Мөнх тэнгэр ба гэгээрэл”, “Манай Монгол” сэтгүүл, 2002, № 01,02 (13, 14)
9. О.Пүрэв, “Монгол бөөгийн шашин”, Улаанбаатар, 1999 он
10. Roy Stemman, “One soul, many lives”, Berkeley, 2005
11. Л.Хүрэлбаатар, “Дуун утгын яруу зохист”, Улаанбаатар, 2005 он
12. Эрнст Мулдашев, “Хүн мичнээс үүсээгүй”, Улаанбаатар, 2004 он
13. Waldemar Jochelson, “The Yakut” Anthropological Papers of The American Museum of Natural history, Volume XXXIII, Part II, 1933

---

1. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 1999 он, х 292

2. С.Дулам, “Дархад бөөгийн уламжлал”, Улаанбаатар, 1992 он, х 16